



СҮХБААТАР АЙМАГ

Хөгжлийн төлөө хамтдаа

СҮХБААТАР АЙМГИЙН 2022 ОНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ



Улаанбаатар хотоос
560 км



Чингис хотоос
230 км



Чойбалсан хотоос
190 км



Дэд бүтцийн
төлөвлгөөтэй



13 сум, 67 багтай



19149 өрхтэй



65 912 иргэнтэй

НИЙТ МАЛЫН ТОО 4 644 799



ДЭД БҮТЭЦ

Иргэдийн амьдрах байр, орон сууцны хүрэлцээ, хангамжийн талаар:

- Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт өрхийн 17 орчим хувь, Баруун-Урт сумын 30 орчим хувь инженерийн хангамжтай орон сууцанд амьдарч байна.
- ЗГ-ын 150 мянга айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд төвлөрсөн болон бие даасан инженерийн хангамжтай тохилог орон сууцны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхээр 960 айлын орон сууцны хорооллын газрыг төлөвлөн шугам сүлжээний ажлыг эхлүүлээд байна. 2020-2022 онд хувийн хэвшлийн хөрөнгөөр 260 айлын орон сууцны барилга баригдсан. /1м² нь 1.850-2.650 төгрөг/ 2023 онд 400 айлын орон сууцны барилга барих хүсэлт гаргаж барилга эхлүүлэх зөвшөөрлөө авсан байна.
- Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслийг 7 га газарт хэрэгжүүлэхээр, мөн орчин үеийн орон сууцны хангамж бүхий Баруун-Урт хотын шинэ “ДЭД ТӨВ” бий болгох хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.



ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, сумын Эрүүл мэндийн төв 12, өрхийн эрүүл мэндийн төв 2, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага 11, эм ханган нийлүүлэх байгууллага 2, эмийн сан 29, нийт 55 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр байгууллагад нийт 851 эмч, эмнэлгийн ажилтан аймгийн 65157 хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын дор үзүүлэн ажиллаж байна.

Улс, аймаг, орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 25 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн.

Эрүүл мэндийн салбар нь нь эрүүл мэндийн анхан шатны болон мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч мэргэжилтнээр бүрэн хангагдсан, үндсэн тоног төхөөрөмжийн хангалт 92 хувьтай байна.



Эмнэлгийн үйлчилгээнд нэвтэрсэн дэвшилтэт техник, технологи, үйлчилгээ

1. Хэвлийн хөндийн мэс заслын дурангийн иж бүрдэл
2. Урологийн дурангийн аппарат
3. Дунд чөмөгний түгжээт мэс засал хийх C-ARM аппарат
4. Нүдний мэс заслын багаж
5. Өвдөгний үе солих мэс засал



Сүхбаатар аймагт БШУГ, НТБТөв, МСҮТ болон ерөнхий боловсролын 16 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 24 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж иргэдэд боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэн ажиллаж байна.

Сургуулийн дотуур байрын хүчин чадлыг бүрэн хангадаг үзүүлэлтээр улсад тэргүүлдэг.


Сургуулийн өмнөх боловсролыг цэцэрлэгээр болон хувилбарт сургалтаар эзэмшүүлдэг бөгөөд СӨБ-ийн хамрагдалт 92%-тай байна.

Ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ 71.46%, нийт сургуулийн 43.7% нь I-IV индексээр үнэлэгдсэн.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээ 87.3%, нийт цэцэрлэгийн 41.7% нь I-IV индексээр үнэлэгдсэн.

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

ЭЕШ-ийн хэмжээст онооны дундаж 518.3, улсын хэмжээнд 6-р байрт эрэмблэгдсэн.



СОЁЛ УРЛАГ

УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙ

Аймгийн угсаатны зүйн музейн онцлог: Монгол Улсын хосгүй үнэт үзмэр 2 ширхэг хадгалагддаг бөгөөд удам дамжсан Дарьганга дархчуудын ухааны ур, гарын ур, нүдний ур шингэсэн мөнгөн урлал сан хөмрөгийн 60%-г эзэлдэг. Тус музей нь Мөнгөн урлал, шашин, сийлбэр, угсаатан, түүх, түр үзэсгэлэнгийн танхим, Жигжиджавын нэрэмжит танхим, байгаль, галерейн 9 танхимтай үйл ажиллагаагаа явуулж байна.



БИЕЙН ТАМИР, СПОРТ

Спортын 2 заал, 3 бэлтгэлийн өрөө, олон улсын стандартад нийцсэн 6 замтай усан спорт чийрэгжүүлэлтийн төвд 14 багш, дасгалжуулагч 20 төрлийн секц, дугуйланд 650 гаруй хүүхэд хичээллүүлж бие бялдрын өв тэгш боловсрол олгон ажиллаж байна. 2022 онд нийт 471 багц медаль хүртээд байна.

Усан спорт сургалтын төв нь Усан бассейн, Фитнесс, Спининг зэрэг үйл ажиллагаа явуулдаг 1872 м2 талбай бүхий цогц байгууламж юм. Өдөрт 200-300 хүн цагт 15-20 хүнд үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой. Ус ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл явц нь MNS6182:2010 стандартын шаардлага хангасан.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Сүхбаатар аймгийн хэмжээнд жилд 700-900 шинэ ажлын байр бүртгэгддэг бөгөөд шинээр бий болж буй ажлын байрыг салбараар нь авч үзвэл 60 гаруй хувийг хөдөө аж ахуй, уул уурхайн салбар эзэлж байна.

Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр 2021 оны жилийн эцсийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 69.6 %, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 67.7%, ажилгүйдлийн түвшин 2.8% байгаа нь улс, бүсийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

“Халамжаас-Хөдөлмөрт” арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах замаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамруулж, ажилласны дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 7 сүм хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхгүй сүм боллоо.

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын 82% нь эрүүл мэндийн даатгалд, эдийн засгийн идэвхтэй хүн амын 47.5% нийгмийн даатгалын үйлчилгээнд тус тус хамрагдаж байна.



УУЛ УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛ

Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт ашигт малтмалын 103 тусгай зөвшөөрөл байна. Үүнээс 68 нь ашиглалт, 22 хайгуул, ТТАМ-ын ашиглалт 2, ТТАМ-ын хайгуул 11 тусгай зөвшөөрөл байна. Газрын тосны хайгуулын 2 талбай /Макс ойл ХХК-ийн Арбулаг, Вульфпетролиум ХХК/ байна.

Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа - 8 ААН /“Цайрт минерал”, “Олгой булаг”, “Эрдэнийн босго”, “Бадмаараг хаш”, “Цэгээн үүдэн”, “Монголжүюаньли”, “Хунт өгөөж” ХХК-үүд /

Голлох ашигт малтмал нь нүүрс - 22, жонш - 13, төмөр - 8, цайр - 3, өнгөт болон ховор металл - 5, холимог металл - 2, гянтболд - 6, Алт - 6 төрлүүд байна.

НӨӨЦ:


Хүрэн нүүрс 8 аж ахуй нэгж боломжит нөөц 1823,6 сая.тн, Цайрын хүдэр 7,7 сая.тн, металл 0,855 сая.тн, төмрийн хүдэр 2 аж ахуй нэгж 108,9 сая.тн, жоншны хүдэр 4 аж ахуй нэгж 2510,0 сая.тн, металлаар 0,988 сая.тн байна.

Бичигтийн боомтоор Газрын тос, Хүрэн нүүрс, Төмрийн хүдэр, Жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн экспортод гарч байна.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Сүхбаатар аймаг нь эцэг өвгөдийн хийж бүтээсэн дахин давтагдашгүй XII-XIII зууны үеийн хүн чулуун урлал, түүний дотроос төв Азийн хүн чулууны сор бүтээл болсон Онгон сумын Таван толгой, Шивээтийн хүн чулуугаараа алдартай бөгөөд эдгээр нь аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн болон сурталчлагдаж байна.




Тэртээ 1696 оноос хойш “Дарьганга хошуу” гэж нэрлэгдэх болсон Дарьгангын ард түмний нүдний ур, гарын урыг гайхалтай харуулсан мөнгөн урлал, тэдгээрийн эдлэж хэрэглэж байсан уламжлалт ёс заншил болох малын хөрсөн хороо, шавар зуух, хэлхээ тоонотой гэр болон Дарьганга угшлын хурдан шандаст хүлгүүдээрээ алдартай нутаг.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Хүн чулуун урлалаас гадна монголчууд түмний шүтэн биширч, хийморио сэргээдэг Алтан овоо, Шилийн богд уул, мөн одоогоос 10-15 сая жилийн өмнө оргилж байсан Монгол орны сөнөсөн галт уулсын 90 орчим хувь болох 200 гаруй эртний сөнөсөн галт уул, түүний үл мөрөөс үүссэн байгалийн өвөрмөгц сонин тогтоц бүхий Талын агуй, Баян дулаан уулын агуй, мянган мянган хүн шувуу чуулах Ганга нуур зэрэг нь зэрэг гадаад дотоодын жуулчдын сонирхолыг татах аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн мөн.



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
Дотоодын нийт бүтээгдэхүүн	590 072.3	сая.төг
Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	9.1	сая.төг
Төсвийн орлого	26 323.4	сая.төг
Төсвийн зардал	33 014.2	сая.төг
Төсвийн тэнцэл	-6 690.8	
Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	100	хувь
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	44	хувь
Ажилгүйдлийн түвшин	2.8	хувь
Ажиллах хүчний оролцооны хувь	69.6	хувь
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	82	хувь
Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч)-ны нийгмийн даатгалд эзлэх хувь	47.5	хувь
Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	650	тоо
Хэрэглээний үнийн индекс	112.7	индекс
Малын тоо	4 644.8	мян. толгой
Хураан авсан үр тариа	3.5	мянган тонн
Хураан авсан малын тэжээл бусад	1.8	мянган тонн
Хураан авсан хүнсний ногоо	872.2	тонн
Хүлээн авах гадаад жуулчдын тоо	237	тоо
Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	732	тоо
Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	15.15	хувь
Төвлөрсөн цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	61.5	хувь

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
Хүн амын дундаж наслалт	73.59	тоо
Хүний хөгжлийн индекс	0.722	индекс
Жендерийн тэгш бус байдлын индекс	0.826	индекс
Бүртгэгдсэн гэмт хэрэг	511	тоо
Иргэдэд учирсан хохиролын нөхөн төлүүлэлтийн түвшин	7.6	хувь
PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж	0.052	М кг/м3
PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж	0.028	М кг/м3
Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	0.02695	хувь
Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	2.7	хувь
Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	23.4	хувь
100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	89.9	промилль
1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдлийн түвшин	8.1	промилль
10000 хүн амд вируст гепатитын өвчлөл	0.9	тоо
Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	98.9	хувь
Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	43.6	хувь
Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	81.3	хувь
Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	63.1	хувь
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	92.0	хувь
Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	95.9	хувь
Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	31.1	тоо
Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	31.1	тоо
Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	518.3	тоо